

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Төрийн болон орон нутгийн хөгжлийн бодлогыг иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн судалгаанд суурилан оновчтой тодорхойлж, нийтэд ил тод, түргэн шуурхай хүргэж, ёс зүйг дээдэлсэн төрийн мэргэшсэн албан хаагч бүхий манлайлан хэрэгжүүлэгч байгууллага байна.

- Судалгаа шинжилгээнд үндэслэгдсэн оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангасан бодлогыг боловсруулж, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дээшлүүлэх
- Ажилтан албан хаагч бүр өөрийн эрхэлсэн салбарын чиглэлээр судалгаа мэдээллийн санг бий болгож, байнга баяжуулж байх
- Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж үр дүнг тооцох
- Байгууллагын үйл ажиллагааны болон төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг ханган ажиллах
- Оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагааг зохион байгуулан сэтгэл ханамжийг тодорхой хувиар тогтмол нэмэгдүүлэн ажиллах
- Ёс зүй, зан харилцааны алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх
- Төрийн үйлчилгээг цахимжуулж түргэн шуурхай иргэдэд хүргэх
- Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, байгууллагын соёлыг төлөвшүүлэн манлайлах

Байгаль орчны бодлого

Төрийн болон орон нутгийн хөгжлийн бодлогыг байгаль орчны хууль эрх зүйн болон байгальд ээлтэй байх шаардлагад нийцүүлэн, байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлж ногоон хөгжлийг бүтээхэд манлайлгч байгууллага байна.

- Байгаль орчныг хамгаалах
- Ажилтан албан хаагч бүр байгальд ээлтэй байх соёлыг түгээгч байх
- Байгаль орчны бохирдлоос ямагт урьдчилан сэргийлэх
- Байгаль орчны хуулийн шаардлагыг сахин биелүүлэх
- Ногоон хотыг бүтээхэд манлайлагч байх
- Хог хаягдлын оновчтой зохион байгуулалтыг хэрэгжүүлэх
- Ногоон байгууламжийг жил бүр нэмэгдүүлэх

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Иргэд олон нийт өргөдөл гомдол, хариуцсан мэргэжилтэн: *М.Энхтайван*

Холбоо барих утас: 70358140

Цахим шуудан: soyol1105@gmail.com